



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/22

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, “Хүмүүн бичигтэн” аян өрнүүлэх тухай аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/60 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хүмүүн бичигтэн” аяны хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Э.Мөнхбаяр (Соёлын төвийн дарга)

Г.Хорол-Эрдэнэ (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Д.Доржханд (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Ц.Мөнхцэцэг (Монгол хэл, Уран зохиолын багш)

Э.Болормаа (Монгол хэл, Уран зохиолын багш)

Нарийн бичгийн дарга Ц.Баасанжав (Насан туршийн боловсролын арга зүйч)

2.“Хүмүүн бичигтэн” арга хэмжээг удирдамжийн дагуу зохион байгуулж, үйл ажиллагааны тайланг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний дотор Өвөрхангай аймгийн Соёл урлагийн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

